



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/421

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох  
тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, 12 дугаар зүйлийн 12.1.2, 19 дүгээр зүйл, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл (2018-2020 он)-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл (2018-2020 он)-ийг баримтлан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Цогтбаатар), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.
3. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Р.Оюунханд), мэргэжил арга зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулахад шаардагдах зардлын санхүүжилтийг шийдвэрлэхийг Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын дарга (Э.Содномжамц)-т тус тус даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн "Чиглэл батлах тухай" А/258 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081678

Эрүүл мэндийн сайдын 2018 оны  
10... дүгээр сарын 19-ны өдрийн  
А/421... дүгээр тушаалын хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл (2018-2020 он)

Нэг. Нийтлэг зүйл

1. Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тасралтгүй байдлыг хангах төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохистой бүрдлийг бий болгоход эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл (цаашид "тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл" гэх)-ийн зорилго оршино.
2. Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Гурван тулгуурт хөгжлийн бодлого, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын зорилго, зорилттой уялдсан байна.
3. Эрүүл мэндийн байгууллагын одоогийн хүчин чадлыг 30 ба түүнээс дээш хувиар нэмэгдүүлэх (цаашид "хүчин чадлыг нэмэгдүүлэх" гэх), зориулалтын барилга байгууламж барих, өргөтгөх, зориулалтаар өөрчлөн засварлах (цаашид "барилга барих, өөрчлөн засварлах" гэх), өндөр өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах, өндөр өртгөөр засварлах (цаашид "эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах, засварлах" гэх) тохиолдолд хэрэгцээний тодорхойлолт гаргаж, тусгай зөвшөөрөл олгоход энэхүү баримт бичгийг удирдлага болгоно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн чиглэлийн хүрээнд 2018-2020 онд баримтлах тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг дор дурдсанаар тогтоож байна. Үүнд:

- 2.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх
  - 2.1.1 Сэргээн засах тусламж, үйлчилгээ:
    - 2.1.1.1 дотрын;
    - 2.1.1.2 мэдрэлийн;
    - 2.1.1.3 сэтгэцийн;
    - 2.1.1.4 тулгуур эрхтний;



- 2.1.1.5 хүүхдийн;
- 2.1.1.6 настны;
- 2.1.1.7 сүрьеэгийн.

2.1.2 Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ:

- 2.1.2.1 дотрын;
- 2.1.2.2 мэдрэлийн;
- 2.1.2.3 хүүхдийн;
- 2.1.2.4 мэс заслын;
- 2.1.2.5 гэмтэл согогийн;
- 2.1.2.6 сэтгэцийн;
- 2.1.2.7 сүрьеэгийн;
- 2.1.2.8 настны;
- 2.1.2.9 хөнгөвчлөх эмчилгээний.

2.1.3 Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ:

- 2.1.3.1 хот, суурин газрын хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээ.

2.1.4 Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ:

2.1.4.1 Үндсэн мэргэшлийн тусламж, үйлчилгээ

- 2.4.1.1.1 эх барихын;
- 2.4.1.1.2 хүүхдийн;
- 2.4.1.1.3 мэс заслын;
- 2.4.1.1.4 гэмтэл согогийн;
- 2.4.1.1.5 халдвартын;
- 2.4.1.1.6 хавдрын;
- 2.4.1.1.7 уламжлалт анагаахын;
- 2.4.1.1.8 сэтгэцийн;
- 2.4.1.1.9 дүрс оношлогооны;
- 2.4.1.1.10 нүүр амны;
- 2.4.1.1.11 нүдний;
- 2.4.1.1.12 чих хамар хоолойн;
- 2.4.1.1.13 дотрын;
- 2.4.1.1.14 мэдрэлийн;
- 2.4.1.1.15 эмэгтэйчүүдийн
- 2.4.1.1.16 арьсны;
- 2.4.1.1.17 түргэн тусламжийн;
- 2.4.1.1.18 зоонозын.

2.1.4.2 Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ

- 2.1.4.2.1 зүрх судасны;
- 2.1.4.2.2 мэдрэлийн (харвалт, тархины судасны);

- 2.1.4.2.3 зүрх, судасны мэс заслын;
- 2.1.4.2.4 мэдрэлийн мэс заслын;
- 2.1.4.2.5 нурууны мэс заслын;
- 2.1.4.2.6 үе бүтээх, солих мэс заслын;
- 2.1.4.2.7 бөөрний мэс заслын;
- 2.1.4.2.8 хавдрын хими эмчилгээ;
- 2.1.4.2.9 хүүхдийн цус, хавдрын;
- 2.1.4.2.10 нярай, перинаталь;
- 2.1.4.2.11 хүүхдийн зүрхний;
- 2.1.4.2.12 хүүхдийн уушиг судлалын;
- 2.1.4.2.13 хүүхдийн хоол боловсруулах тогтолцооны;
- 2.1.4.2.14 хүүхдийн нүүр амны;
- 2.1.4.2.15 хүүхдийн мэдрэлийн;
- 2.1.4.2.16 хүүхдийн нүдний;
- 2.1.4.2.17 хүүхдийн өсвөр үеийн сэтгэцийн;
- 2.1.4.2.18 хүүхдийн мэс заслын;
- 2.1.4.2.19 хүүхдийн гэмтэл согогийн;
- 2.1.4.2.20 эх барихын;
- 2.1.4.2.21 эхийн ураг судлалын;
- 2.1.4.2.22 эмэгтэйчүүдийн;
- 2.1.4.2.23 ревматологийн;
- 2.1.4.2.24 эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн;
- 2.1.4.2.25 эмнэлзүйн хордлого судлалын;
- 2.1.4.2.26 настны;
- 2.1.4.2.27 сэтгэцийн;
- 2.1.4.2.28 сэтгэл судлалын;
- 2.1.4.2.29 донтолтын;
- 2.1.4.2.30 спортын анагаахын.

2.2 Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх:

- 2.2.1 Уламжлалт эм, тангийн үйлдвэрлэл, эмийн түүхий эд импортлох;
- 2.2.2 Уламжлалт эм, тан экспортлох;
- 2.2.3 Импорт орлох эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл;
- 2.2.4 Оношлогоо, эмчилгээний зориулалтаар шинээр гарч байгаа био болон нано технологид суурилсан инновацийн бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл;
- 2.2.5 Эмийн үйлдвэр өөрийн үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эд, туслах бодис импортлох.

2.3 Эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм худалдах:

- 2.3.1 Эмийн сангийн үйлчилгээ дутагдалтай газар нутгийн хүн амд эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа.



2.4 Биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох, экспортлох, ханган нийлүүлэх, үйлдвэрлэх:

2.4.1 Биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх;

2.4.2 Биологийн идэвхит бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

2.4.3 Биологийн идэвхит бүтээгдэхүүн экспортлох.

2.5 Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, түүний засвар үйлчилгээ эрхлэх:

2.5.1 Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ эрхлэх;

2.5.2 Эмнэлгийн багаж, тоног, төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх;

2.5.3 Оношлогоо, эмчилгээний зориулалтаар шинээр гарч байгаа био болон нано технологид суурилсан инновацийн бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл.

2.6 Эмнэлгийн протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх:

2.6.1 Импорт орлох дэвшилтэт технологи бүхий эмнэлгийн протезын үйлдвэрлэл;

2.6.2 Эмнэлгийн протез импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ.

2.7 Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх

2.7.1 Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, ханган нийлүүлэх.

2.8 Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх:

2.8.1 Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ;

2.8.2 Ариутгалын үйлчилгээ.

### **Гурав. Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх хүрээ**

3.1 Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн 2.1.1-2.1.2, 2.1.3, 2.1.4, 2.2.1-2.2.3, 2.3, 2.5.2, 2.6-2.8-д заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээ дутагдалтай, хүртээмжгүй байгаа төрлөөр үйл ажиллагаа шинээр эрхлэх тохиолдолд тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.

3.2 Хуулиар тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний өрсөлдөөнийг бий болгох, төвлөрлийг сааруулах, давхардлыг арилгах зорилгоор зохион байгуулалт, байршлыг оновчтой болгоход тусламж, үйлчилгээний болон хөрөнгө оруулалтын төлөвлөлт дээр тулгуурлан сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

3.3 Дүүргийн нэгдсэн эмнэлгийн өрсөлдөх чадавхи, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн 2.1.4.1-д заасан тусламж,

үйлчилгээний төрлөөр хэрэгцээний тодорхойлолтыг үндэслэн тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулна.

3.4 Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн 2.1.4, 2.2.4 болон 2.5.1, 2.5.3-т заасан төрлөөр хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх, барилга барих, өөрчлөн засварлах, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах, засварлахад хэрэгцээний үнэлгээ хийж, хэрэгцээний тодорхойлолт гаргаж, тусгай зөвшөөрөл олгоно.

3.5 Гадаад зээл тусламж, Засгийн газрын гэрээ, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн барилга шинээр барьсан, өөрчлөн засварласан тохиолдолд тусгай зөвшөөрлийн тэргүүлэх чиглэлийн 2.1.4.1 болон 2.1.4.2-т заасан тусламж, үйлчилгээний төрлөөр зохих журмын дагуу тусгай зөвшөөрөл олгоно.

3.6 Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн 2.2.4, 2.4, 2.5.3-т заасан төрлөөр зохих журмын дагуу эмнэл зүйн туршилтын үр дүн болон шинжилгээний дүн, улсын бүртгэлд бүртгүүлсэн байдлыг харгалзан тусгай зөвшөөрөл олгоно.

3.7 Энэхүү тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын тоо, газар зүйн байршил, онцлог, эрүүл мэндийн үзүүлэлтийг үндэслэн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохистой бүрдлийг бий болгоход дараах зарчимд тулгуурлана. Үүнд:

- 1) Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
- 2) Тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, хүн амд тусламж, үйлчилгээг ойртуулах;
- 3) Тусламж, үйлчилгээний давхардлыг арилгаж, ачаалал хуваалцахад чиглүүлэх;
- 4) Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний давуу эрхийг задлах, чанар, хүртээмжийг сайжруулах өрсөлдөөнийг дэмжих.